



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/505

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алтаргана 2024” олон улсын XV их наадмын урлаг, соёлын арга хэмжээнд оролцох 100 хүүхдийг “Жаргалант” зусланд байршуулан, бэлтгэлийг хангуулан ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар (Т.Баярбат)-т даалгасугай.

2. Урлаг, соёлын арга хэмжээнд оролцох 100 хүүхдийг “Жаргалант” зусланд байршуулан бэлтгэл хангаж ажиллахад шаардагдах 47,002,000 (дөчин долоон сая хоёр мянга) төгрөгийг хавсралтаар батлан санхүүжилтийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн “Алтаргана 2024” арга хэмжээний төлөвлөгдсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ

6324010674

07 дүгээр сарын 17-ны өдрийн 1/505 дугаар
Аймгийн Засаг даргын 2024 оны
захирамжийн хавсралт



“Алтаргана 2024” олон улсын XV их наадамд оролцох урлаг соёлын 100 хүүхдийн
бэлтгэл хангаж ажиллахад шаардагдах төсөв

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
0	1	2	3	4
1	100 хүүхдийг тээвэрлэх шатахуун	273 л	3,670	1,002,000
2	Хоол	8 өдөр * 100 хүүхэд	45,000	36,000,000
3	Урамшуулал	8 өдөр * 100 хүүхэд	50,000	5,000,000
4	Ажилчдын хөлс	8	625,000	5,000,000
Нийт үнэ				47,002,000

-----oOo-----